

ЦЭРГИЙН ШТАБЫН ТОО БҮРТГЭЛИЙН АХЛАХ ОФИЦЕР ХОШУУЧ Н.БАЯНМӨНХИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
НЭГ."БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ СУРТАЛЧЛАХ, ХЭРЭГЖИЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.1.	Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомж, үйл ажиллагааг бүх нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах	Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны хуваарийн дагуу зохион байгуулж иргэдийн тодорхой хувийг хамруулах	Иргэдийн 15 хүртэлх хувийг хамруулсан	Иргэдийн 20 хүртэлх хувийг хамруулна	2024 оны 03 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд Орхон аймаг дахь, "Эрдэнэт цогцолбор" дээд сургууль, Политехникийн коллеж болон ЕБС-ын ахлах ангийн сурагчдын дунд батлан хамгаалах, Зэвсэгт хүчний сурталчлах нийт 3 төрлийн арга хэмжээг зохион байгуулсан.	04 дүгээр сард	100%
1.2.	"Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 103 жилийн ойн баярын арга хэмжээг тусгай төлөвлөгөөгөөр зохион байгуулах	Арга хэмжээг тогтоосон хугацаанд зохион байгуулах	Төлөвлөсөн арга хэмжээг зохион байгуулсан байх	Төлөвлөсөн арга хэмжээг зохион байгуулсан	Аймгийн Засаг даргын 2024 оны А/92 дугаар захирамжийн дагуу "Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 103 жилийн ойн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд жил бүр зохион байгуулагддаг аймгийн Засаг даргын нэрэмжит "Марш-тактикийн аварга тасаг" шалгаруулах цогцолбор тэмцээнийг 2024 оны 03 дугаар сарын 15-ний өдөр Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн сургалтын төвд зохион байгуулж, аваргуудаа тодрууллаа.	03, дугаар сард	100%

				Аймгийн биеийн тамир, спортын газартай хамтран хүчит 64 бөхийн барилдааныг 2024 оны 03 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан. "Эх орны төлөө" хүндэтгэлийн баярын үйл ажиллагааг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын "Соёл урлагийн цогцолбор"-ын их танхимд зохион байгуулсан. Уг арга хэмжээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт ажиллаж байсан үе үеийн ахмадууд, Эрдэнэт хотод ажиллаж, амьдарч байгаа бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмадууд, Зэвсэгт хүчний 110, 186 дугаар ангиудын байнгын бие бүрэлдэхүүн болон хугацаат цэргийн алба хаагчдыг ар гэрийн төлөөлөл, хайртай хүмүүстэй нь уулзуулж хамтад нь баярын концерт үзүүлж бэлэг барьлаа. Мөн аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн 18 нас хүрсэн залууст цэргийн үүрэгтний үнэмлэхийг гардуулаж өглөө. Үндсэн хуулиа дээдлэн иргэний үүргээ биелүүлэн эх орныхоо халдашгүй дархан байдлыг сахин хамгаалах их үйлсэд гар бие оролцохыг залууст уриалсан энэхүү арга хэмжээнд залуусын төлөөлөл болсон 60 гаруй сурагч оролцлоо. Аймгийн Засаг даргын орлогч А.Түвшинжаргал, Цэргийн штабын дарга хурандаа Б.Оюунтүлхүүр нар Орхон аймагт амьдарч байгаа 1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчин Г.Дугаржавт хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардуулсан. "Монгол цэргийн өдөр", Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн	
--	--	--	--	---	--

					байгуулагдсаны 103 жилийн ойн баярыг тохиолдуулан Төр, нийгмийн зүтгэлтэн Ерөнхий сайд асан А.Амарын хөшөөнд цэцэг өргөж хүндэтгэл үзүүлжээ. Монгол Улсын Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг аймгийнхаа иргэдэд төдийгүй, орон нутагт ажиллаж байгаа гадаадын иргэдэд сурталчилсан, өсвөр насны хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч хүмүүжил олгосон, Эх орон газар нутаг, эцэг өвгөдийн байгуулсан баатарлаг түүх, даян дэлхийн энхийн үйлсэд Монгол цэргийн оруулсан гавьяаг таниулсан чухал ач холбогдолтой арга хэмжээнүүд болсон.		
1.3.	“Цэрэг спортын Дөл цогцолбор тэмцээн”-ийг зохион байгуулах	2 удаа	1 удаа	Удирдамжийн дагуу 2 үе шаттай зохион байгуулна.	Орхон аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газраас баталсан “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”, Их эзэн Чингис хаан мэндэлсний 862 жилийн ойн хүрээнд хүүхэд, залуучуудад тусгаар тогтнол, үндэсний эрх, эрх чөлөөний үнэ цэнийг ойлгуулах, эх орноороо болон Монгол хүн болж төрснөөрөө бахархах, эх байгаль, түүх соёлоо хайрлан хамгаалах ухамсартай, эх оронч иргэнийг төлөвшүүлэх, Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Орхон аймагт төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрээний 1.6 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2024 оны А/603 дугаар захирамжийн дагуу	09 дүгээр сар	100%

					аймгийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын “ДӨЛ” цогцолбор тэмцээнийг 2024 оны 09 дүгээр сарын 21, 22-ны өдрүүдэд аймгийн Эрдэнэт спорт амралтын хүрээлэнд амжилттай зохион байгууллаа. Тус тэмцээнд 12 сургуулийн 156 сурагч хурд, хүч, авхаалж самбаа, мэдлэг чадвараа сорин асуулт, хариулт, эсээ бичлэгийн уралдаан, гарааны өмнөх ажиллагаа буюу жагсаалын үзүүлэх тоглолт, гардан тулааны үзүүлэх тоглолт, тасгийн захирагчийн тэмцээн, марш гүйлтийн тэмцээн зэрэг 16 төрлөөр зохион байгуулж явууллаа. Тэмцээний нийлбэр дүнгээр: “Тэргүүн байрт”-т Ж.Батнайрамдал тасгийн захирагчтай Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын 14 дүгээр сургууль шилжин явах цом, алтан медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, “Дэд байрт”-т Б.Анх-Энх тасгийн захирагчтай ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль мөнгөн медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, “Гутгаар байрт”-т Х.Мөнхсүврага тасгийн захирагчтай ерөнхий боловсролын 7 дугаар сургууль хүрэл медаль, өргөмжлөл мөнгөн шагнал, “Тусгай байр”-т Ж.Намуун-Эрдэнэ тасгийн захирагчтай 18 дугаар сургууль өргөмжлөл мөнгөн шагналаар тус тус шагнагдсан байна.		
1.4.	Нууц баримт бичиг, бусад нууц тээгчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдалд нэг бүрчлэн тооллого хийж, шалган хадгалалт хамгаалалтын байдал.	Нууц баримт бичиг, бусад нууц тээгчийн ашиглалт,	Жилд 2 удаа тооллого хийх	Жилд 2 удаа тооллого хийсэн	Монгол Улсын Төрийн болон албаны нууцын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон албаны	06, 12 дугаар сар	100%

	түүнийг сайжруулах талаар авч арга хэмжээний талаарх санал, дүгнэлтийг тусган акт бичиж нэг хүвийг Зэвсэгт хүчний Жанжин штабт хүргүүлэх	хадгалалт, хамгаалалт хяналт сайжирна			нууцыг хамгаалах нийтлэг журам"-ын 12.4 дэх заалт, "Монгол Улсын Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журам"- ын 7 дугаар бүлгийн 7.23 дахь заалтуудыг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 06 сарын 06-ны өдрийн А/37 дугаар тушаал, 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/53 дугаар тушаалаар томилогдсон тооллогын комисс Цэргийн штабт ашиглагдаж байгаа дайчилгааны бэлэн байдлын онц чухал нууц, маш нууц, нууц баримт бичгийн эхний хагас болон жилийн эцсийн тооллого, шалгалтыг явуулж, тайлан, мэдээг БХЯ, ЗХЖШ-ын газар, хэлтсүүдэд хүргүүлсэн. ЗХЖШ-ын даргын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/169 дүгээр тушаалаар томилогдсон шалган туслах ажлын хэсгийн бүрэлдэхүүн Цэргийн штабт ашиглагдаж, хадгалагдаж байгаа нууц баримт бусад нууц тээгчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдалд үзлэг, шалгалтыг хийсэн. Бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжих, гал түймэр, гэнзтийн ослын үед дайчилгааны нууцаас авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, авран хамгаалах төлөвлөгөө, схем хийж ажилласан ба нууц хадгалалт, хамгаалалтын талаар авч хэрэгжүүлсэн ажил, баримт бичгийн боловсруулалт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тогтмол хяналт тавьж, заавар журмыг хангаж ажилласнаар зөрчил дутагдал гаргаагүй.	
--	---	--	--	--	---	--

ХОЁР."ЦЭРГИЙН БҮРТГЭЛ ЦЭРЭГ ХАЛАЛТ, ТАТЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАХ ЦЭРГИЙН АЛБЫГ БИЕЭР ДҮЙЦҮҮЛЭН ХААЖ БАЙГАА ИРГЭДТЭЙ СУРГАЛТ ЯВУУЛАХ, МӨНГӨН ТӨЛБӨРИЙН ТООЦОО ХИЙХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

2.1.	Хугацаат цэргийн албаны цэрэг халалт, татлагыг зохион байгуулах	Хуулийн дагуу хугацаат цэргийн алба хаалгах	Хяналтын тоог 100 хувь биелүүлнэ	Хяналтын тоог 100 хувь биелүүлнэ	Аймгийн Засаг даргын 2024 оны А/279 дүгээр захирамжийн дагуу 2023 оны I ээлжээр татагдсан цэргүүдийг хүлээн авах, 2024 оны I ээлжийн цэрэг татлагын ажлыг зохион байгуулах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. 2024 оны 04 дүгээр сарын 26, 27-ны өдрүүдэд I ээлжийн цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулж, 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Хилийн цэргийн төв дамжинд хүргэж, хүлээлгэн өгсөн. Мөн аймгийн Засаг даргын 2024 оны А/697 дугаар захирамжийн дагуу 2023 оны II ээлжийн цэрэг халалт, 2024 оны II ээлжийн цэрэг татлагын ажлуудыг хийж гүйцэтгэсэн. 2024 оны 10 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд II ээлжийн цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулж, 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Зэвсэгт хүчний Төв дамжинд хүргэж хүлээлгэн өгсөн. Ээлжит цэрэг татлагууд зохион байгуулсан тухай холбогдох мэдээ тайланг маягтын дагуу боловсруулан БХЯ, ЗХЖШ-ын холбогдох газар, хэлтсүүдэд хүргүүлсэн.	05, 10 дугаар сар	100%
2.2.	Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзлыг хангасан иргэдийн төлбөр төлөлтөд хяналт тавих, бүртгэл тооцосг хөтлөх	Хуулийн дагуу цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах	Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэдийн төлбөрийг 100 хувь барагдуулна	Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэдийн төлбөрийг 100 хувь барагдуулсан	2024 оны I ээлжийн цэрэг татлагаар цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн 158 иргэнийг Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаалгаж, мөнгөн төлбөрийн орлого 200.5 сая төгрөгийн 50 хувь болох 100.2 сая төгрөгийг Сангийн яам "Төв төрийн" сан дахь 900000704 дугаарын дансанд шилжүүлж,	06 сард	100%

					орон нутагт үлдэх 100.2 сая төгрөгийг Засаг даргын Тамгын газрын нэмэлт 100210051409 дугаарын тоот дансанд шилжүүлсэн. 2024 оны II ээлжийн цэрэг татлагаар цэргийн алба хаах насны дээд хязгаар хүрсэн 42 иргэнийг Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаалгаж, мөнгөн төлбөрийн орлого 47.5 сая төгрөгийн 50 хувь болох 23.7 сая төгрөгийг Сангийн яам "Төв төрийн" сан дахь 900000704 дугаарын дансанд шилжүүлж, орон нутагт үлдэх 23.7 сая төгрөгийг Засаг даргын Тамгын газрын нэмэлт 100210051409 дугаарын тоот дансанд шилжүүлсэн.		
2.3.	Хугацаат цэргийн алба хааж буй дайчдын цэргийн албаны үйл ажиллагаатай танилцах, тэдний ар гэрт нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх	Хугацаат цэргийн алба хааж буй дайчдын ар гэрийг дэмжих	Хугацаат цэргийн алба хааж буй дайчдын ар гэр 20 хувьд туслалцаа үзүүлэх	Хугацаат цэргийн алба хааж буй дайчдын ар гэр 20 хүртэлх хувьд туслалцаа үзүүлсэн	Хугацаат цэргийн алба хааж байгаа цэргүүдийн ар гэр болох 10 өрхөд түлээ, нүүрсний тусламжийг дэмжлэг болгон үзүүлсэн.	06, 11 дүгээр сард	100%
2.4.	Цэргийн бүртгэлийг хөтлөх, зохион байгуулах	Үүрэг гүйцэтгэх бэлэн байдал дээшилнэ	Шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж, бүртгэлжүүлнэ	Шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж, бүртгэлжүүлсэн	Аймгийн Засаг даргын А/847 дугаар захирамжийн дагуу Цэргийн бүртгэлийн ажлыг зохион явуулж, 18-50 насны иргэдийг хамруулж, аймгийн хэмжээнд 90,6 хувьтай явагдсан. Мөн аймгийн Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран цэргийн насны залуучуудын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих ажлыг зохион байгуулж байна.	02. 03 дугаар сард	100%

2.5.	“Оюутан-цэрэг” сургалтын цэргийн ерөнхий бэлтгэл шатны сургалтыг зохион байгуулах	Мэргэжлийн ур чадвар эзэмшинэ	Хуулийн дагуу цэргийн алба хаалгах	Оюутан-цэрэг” цэргийн сургалтыг 1 удаа зохион байгуулна	Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын 2024 оны А/35 дугаар тушаал, аймгийн Засаг даргын А/208 дугаар захирамжийн дагуу 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс 06 дугаар сарын 06-ны өдөр хүртэл Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас томилогдсон бие бүрэлдэхүүн Цэргийн штабын Сургалтын танхимд бямба, ням гарагуудад өдрийн 6 цагаар, 16 өдрийн, 96 цагийн “Оюутан-цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтын цэргийн ерөнхий бэлтгэл шатны онолын сургалтыг зохион явуулсан.	03-08 дугаар сард	100%
ГУРАВ.”ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
3.1.	Цэргийн насны залуусын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих	Орон нутагт завсардах байдал багасах	Шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж, бүртгэлжүүлнэ	Шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж бүртгэлжүүлсэн	Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран цэргийн насны залуучуудын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих ажлыг зохион байгуулж байна. Эхний хагас жилийн байдлаар Улаанбаатар хот болон өөр аймаг руу шилжсэн 18-50 насны 41, шилжиж ирсэн 7 иргэн бүртгэгдсэн байна.	01-12 дугаар сар дуустал	100%
3.2.	Цэргийн насны залуусыг эрүүлжүүлэх талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах, үр дүнг нь тооцох	Цэргийн насны залуучуудыг эрүүлжүүлж хуулийн дагуу хугацаат цэргийн алба хаалгах	Цэргийн насны иргэдийг эрүүлжүүлэх арга хэмжээ авч ажиллана	Цэргийн насны иргэдийг эрүүлжүүлэх арга хэмжээ авч ажилласан	Засгийн газрын 2019 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан “Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчдын эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам”-ыг баримтлан 2024 оны I ээлжийн цэрэг татлагын үзлэгээр эрүүл мэндээр тэнцэхгүй дүгнэлттэй гарсан боловч эмчлэгдэх боломжтой 18-25 насны 8 иргэнийг, 2024 оны II ээлжийн цэрэг татлагын үзлэгээр 12	05, 10 дугаар сард	100%

					иргэний эрүүл мэндийн түвшинг дээшлүүлэх, эрүүлжүүлэх ажлыг Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Эрүүл мэндийг дэмжих төв, өрхийн эмнэлгүүдийн хяналтад авч бүртгэл хийн, эмчилгээ хийгдсэн.		
3.3.	Аймгийн цэрэг-стратегийн үнэлгээг нийгэм, эдийн засгийн статистик үзүүлэлтэд үндэслэн цэргийн ажиллагаанд үзүүлэх нөлөөг бодитойгоор тооцон боловсруулж дүгнэлт гаргах	Аймгийн цэрэг-стратегийн үнэлгээг нийгэм, эдийн засгийн статистик үзүүлэлтэд үндэслэн боловсруулах	Аймгийн цэрэг-стратегийн үнэлгээг нийгэм, эдийн засгийн статистик үзүүлэлтэд үндэслэн боловсруулна	Аймгийн цэрэг-стратегийн үнэлгээг нийгэм, эдийн засгийн статистик үзүүлэлтэд үндэслэн боловсруулсан	Цэргийн штабын төлөвлөгөөний дагуу Аймгийн цэрэг-стратегийн үнэлгээг нийгэм, эдийн засгийн статистик үзүүлэлтэд үндэслэн боловсруулсан.	01, 03 дугаар сард	100%
3.4	Батлан хамгаалах салбарын төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх	1.Өргөдлийн тоо 2.Лавлагааны тоо 3.Хугацаа	88 удаа	Хагас жилийн хугацаанд ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэнэ.	1.Цэргийн штабт иргэдээс ирүүлсэн 75 өргөдлийг хуулийн дагуу хугацаанд нь шийдвэрлэсэн 2.Архивын лавлагаа хүссэн 14 иргэнийг чиглүүлж ажилласан. 3.01-12 сард	01-12 сард	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
НЭГ. "МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ"							
1.	БД/100	Тасаг, салаа, рот тактикийн ажиллагааны чадвар нэмэгдэнэ	Эзэмшвэл зохих мэдлэг сайжрах	Эзэмшвэл зохих мэдлэг сайжирна	Баасан гариг бүр 18-20 цагийн хооронд уншиж судалсан	01-12 дугаар сард	100%
2.	Биеийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх	Биеийн жингийн зохистой харьцааг хангах	Жингийн илүүдэлтэй	7 хоногт 2-оос доошгүй удаа спортоор хичээллэх	5.1 кг хассан	07-12 дугаар сард	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Тоо бүртгэлийн ахлах офицер/Хошууч Н.Баянмөнх/
Албан тушаал (гарын үсэг, нэр)

2024.12.03
.....
(Огноо)